ойлгуулж даруй шийдвэрлэх нь шаардлагатай байна. Харилцан ажиллагааны үед тухайн үүссэн нөхцөл байдлыг эхнээс нь эцэс хүртэл удирдах байгууллага нь тодорхой бус байгаа зэргийг тогтоон нарийвчлан авч үзэх нь чухал юм.

4. Харилцан ажиллагаа нь албан үүргийн дагуу эрх зүйн актуудад үндэслэгдэн зайлшгүй гүйцэтгэх үүрэг, зааврыг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжддэг харин хамтын ажиллагаа нь гэрээ, хамтран ажиллах санамж бичгийн хэлбэрээр хэрэгждэг олон хэлбэртэйгээрээ болон агуулгын хувьд ялгаатай асуудал гэж үзэх оновчтой байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа Б.Сайнболор*

## ОЛОН УЛСЫН ЦЭРЭГ-УЛС ТӨРИЙН БАЙДАЛ НЬ МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД нөлөөлөх нь

**Нэг. Цэрэг-улс төрийн байдал, түүнйй орнөлт**

Цэрэг-улс төрийн байдал гэдэг ойлголт (ухагдахуун) нь тухайн бүс нутагт оршин тогтнож байгаа улс, орнуудын улс төр, нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлын нөлөөллөөр ямагт хөдөлгөөнтэй буюу өрнөлттэй байдаг бөгөөд энэ чанараараа байнга бусдын анхаарлын төвд байж ямар нэг хэмжээний эрсдэл дагуулж явдаг онцлогтой. Энэхүү эрсдэл нь тухайн улс болон бусад улсуудын хувьд ямар нэг хэмжээгээр эерэг, сөрөг үйл явцыг бий болгох бөгөөд үүнийхээ үр дүнд нэг талынх нь ашиг сонирхлыг хангаж, нөгөө талынх нь ашиг сонирхолд хохирол авчирч байдаг. Энэ утгаараа олон улсын түвшинд ч, Зүүн хойд Азийн бүс нутгийн хувьд ч цэрэг-улс төрийн байдал XX зууны эхэн үеэс өнөөг хүртэл байнгын хөдөлгөөнтэй байж түүнийхээ хөгжлийн явцад агуулга, шинж чанарын хувьд ихээхэн өөрчлөгдөж байсан байна.

Монгол Улсын оршин буй зүүн хойд Азийн бүс нутаг нь энэ хугацаанд байнга хувьсан өөрчлөгдөж улс, үндэстэн хоорондын үзэл бодол, байр суурийн зөрчил, сөргөлдөөний талбар байсан бөгөөд өдгөө ч уг үйл явц эрсдэл дагуулсан асуудал хэвээр байсаар байна. Өөрөөр хэлбэл зүүн хойд Азийн орнуудын улс төрийн байгууламж, үзэл суртлын ялгаа, хүйтэн дайнаас улбаатай харилцан бие биедээ үл итгэдэг явдал бүс нутагт маргааныг зохицуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ авахад гол саад тотгор болсоор байна.

Хэдийгээр газар зүйн байрлал болон улс төрийн нөлөөллөөрөө зүүн хойд Азид дэлхийн их гүрнүүдийн дөрөв нь, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүний гурав нь, дэлхийн хамгийн том эдийн засагтай орнуудын гурав нь оршдог боловч тус бүс нутагт цэрэг-улс төрийн байдал тогтворгүй, үл ойлголцол, мөргөлдөөн гарч болзошгүй үзэл бодол, байр суурийн зөрчилдөөний аюул, эрсдэл бүхий талбар хэвээр байна.

Уг аюул, эрсдэл нь үйл явцынхаа зорилго, учир шалтгаан, шинж чанар, хамрах хүрээнээсээ хамааран төрөл бүрийн агуулга, хэлбэрээр гарч болзошгүй болжээ. Түүнчлэн учирч болзошгүй аюул буюу эрсдэлийн тухай бидний төсөөлөлд

ихээхэн өөрчлөлт орж уламжлалг аюулын зэрэгцээ үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал, дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт, цагаачлал гэх мэт улс орны хил хязгаараар зааглагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхий нийтийг хамарсан шинэ аюул занал болон хувирч байна.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэл гэдэг нь явцуу хүрээндээ нутаг дэвсгэрийн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдалд үзүүлэх нөлөөлөл болох нь тодорхой болж байна. Энэ нөлөөллийг зүүн хойд Азийн цэрэг-улс төрийн байдал талаас нь гадаад болон дотоод хүчин зүйлсээр нь дараах байдлаар ангилж болох юм. Үүнд:

*Гадаад хүчин зүйлсийн тухайд:*

1. Зүүн хойд Азийн бүс нутагт хэдийгээр маргаантай асуудлууд цөөнгүй байгаа боловч ойрын ирээдүйд тус бүс нутаг том дайн, зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал үндсэндээ байхгүй ч улс орнуудын гадаад бодлогод энх тайван, тогтвортой хөгжлийн төлөө нэгдэн тэмцэх эрмэлзэл давамгайлах нь улам бүр мэдрэгдэх шинжтэй байна.
2. Аливаа бүс нутаг, улс оронд үүссэн хямралт байдлаас гарахад дэлхийн улсуудын хамтын ажиллагаа болон улс хоорондын олон талт харилцааг зохицуулах зорилго бүхий НҮБ, АСЕАН, АПЕК, НАФТА, НАТО, ЕАБХАБ, Европын холбоо гэх мэт байгууллагын үүрэг эрс нэмэгдэж байна.
3. Үзэл санаагаараа нэгдсэн иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа идэвхжиж, тэдний зүгээс Засгийн газартаа хүчтэй нөлөөлөхийг оролдох, зарим тохиолдолд зөрчил, сөргөлдөөнд хүрэх нөхцөл үүсч байна.
4. Мэдээллийн технологи, шинэ материалын үйлдвэрлэл, нана, био, байгальд хоргүй, сансарын гэх мэт орчин үеийн технологийн хөгжил ойрын ирээдүйд улам хурдсах нь тодорхой болж байна.
5. Манай улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төрийн байгуулалтад гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул үндсэндээ байхгүй байна.
6. Улс орнуудын хувьд хилийн шугамаар хязгаарлагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд нүүрлэсэн шинэ аюул занал болон хувирч байна.

*Дотоод хүчин зүйлсийн тухайд:*

1. Улс төрийн тогтворгүй байдлаас улбаатайгаар төрийн хууль ёсыг дээдлэн хүндлэх монгол сэтгэлгээ алдагдаж, хил орчмын ард иргэдийн дунд хагалан бутаргах, салан тусгаарлах болон хүн амын ашиг сонирхлыг эсрэг улс төрийн буюу шашны үзэл санааг сурталчлах, түүнтэй тэмцэх төрийн механизмыг зориудаар хүчгүйжүүлэх, хяналтыг сулруулах оролдлого хийгдэж болзошгүй.
2. Эдийн засгийн дорой байдал хүн амын орлогын чадамжгүй байдал, ядуурлаас шалтгаалан төрийн байгууллагын алба хаагчдыг худалдан авах (авлига),

хил орчмын байгалийн баялгийг хууль бусаар олборлох, түүнийг дагасан төрөл бүрийн гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл бүрдэж байна.

3. Монгол Улсын гадаад харилцаа улам бүр өргөжиж хүн, мал, бараа бүтээгдэхүүний урсгал чөлөөтэй болох тутам түүнийг дагасан элдэв халдварт өвчин тархах, байгалийн гамшиг учрах аюул бодитой оршиж байна.

4. Орон нутгийн зарим иргэд нөгөө улсын иргэдтэй үгсэн хуйвалдах замаар улсын хилээр хууль бусаар мал, байгалийн баялаг, бусад эд зүйлсийг нэвтрүүлэх (завдах), уг зорилгоо биелүүлэхийн тулд бүлэглэл бий болгон үйл ажиллагаагаа өргөжүүлэх шинжтэй байна.

5. Хүн амын тодорхой хэсэг оюун санаа, эрүүл мэндийн доройтлын хэмжээнд хүрэхүйц ядууралд орсныг далимдуулан тэднийг төрийн бодлогын эсрэг аливаа үйл ажиллагаанд ашиглах, амь насыг нь эрсдүүлэх асуудал бий болж болзошгүй байна.

6. Төрийн байгууллагын албан хаагчдын цалин хангамж, ажиллах, амьдрах орчин нөхцөл хангалттай хэмжээнд бүрдээгүйг далимдуулан тэдэнд дэмжлэг үзүүлэх нэрийн дор гэмт хэргийн золиос болгох, уруу татах, зорилгоо биелүүлэхийн тулд авлига өгөх гэх мэт асуудлууд байж болох юм.

**Хоёр. Цэрэг-улс терийн байдал, төрөөс хилийн талаар баримтлах бодлогод нөлөөлох нь**

Даяаршиж буй өнөөгийн нөхцөлд дэлхий дахины хөгжлийн ерөнхий хандлага, төлөв нь манай гадаад орчин, язгуур ашиг сонирхолд хэр нөлөөлж болохыг урьдчилан харахад хэцүү билээ. Хэдий тийм боловч бодит мэдээлэл, нарийн ажиглалт, судалгаанд үндэслэж Монгол Улсын гадаад орчин, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжилд учирч болзошгүй аюул, саад тотгорыг зөв тооцоолон тодорхойлж, урьдчилан сэргийлэх, аюулыг зайлуулах буюу хамгийн бага эрсдэлтэйгээр давж туулах зөв арга шийдлийг олж байх нь чухал юм. Иймд эрсдэлийг үнэлэхдээ юуны өмнө бодит мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, шийдлийн хамгийн зөв сонголтыг олж тогтоон шийдлийг бүрэн гүйцэтгэхэд чиглэсэн төрөөс авч хэрэгжүүлэх бодлоготой байх учиртай.

Төрийн бодлого гэдэг нь тодорхой нөхцөлд зорилго, түүнд хүрэх арга замыг сонгохын тулд улс төрд оролцогч буюу хэсэг оролцогчоос гаргасан харилцан холбоо бүхий цогц шийдвэр юм[1]. Өөрөөр хэлбэл төрийн бодлого нь түүнээс батлагдан гарч буй хууль тогтоомж, зарлиг, шийдвэр, хууль нь тухайн төр улсыг бүрдүүлж буй иргэдийн ахуй амьдрал, зориулагдаж буй хүрээнийхээ асуудлуудыг зохицуулахаар гарч буй шийдвэрүүд билээ.

Монгол Улсын Их хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг батлан хэрэгжүүлж эхэлсэн.

"Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” гэдэг нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй

[1] Уиллъям Женкинс. Төрийн бодлого.УБ. 2006. 11 дэх тал.

хэсэг болсон Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг юм.

Тэгвэл “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжүүлэгч үндсэн субьект нь төр буюу Хил хамгаалах байгууллага болон иргэн болж байна. Мөн хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт, материал техникнйн хангамжийн норм хэмжээг тогтоох, холбогдох журмыг мөрдүүлэх, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг асуудлыг Засгийн газар, бодлогод олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутаг, хил залгаа улс дахь цэрэг-улс төрийн байдал, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх асуудлуудыг тус тус хариуцуулсан байдаг.

Аливаа аюул, эрсдэл манай нутаг дэвсгэрт улсын хилээр нэвтрэн (эсвэл зөрчин) газар, ус, агаарын болон газрын хэвлийн хилээр орж ирэх нь дамжиггүй юм. Тэгвэл манай төр, хилчид, иргэн бүс нутгийн цэрэг-улс төрийн байдлаас шалтгаалан хилээр орж ирсэн аливаа хөдөлгөөн (зөрчил)-ийг үнэлж, дүгнэх, хариу үйлдэл үзүүлэхэд бэлэн үү? Энэ асуултад хариулахын тулд өнөөдөр эрх зүйн үндэслэл ямар түвшинд байгааг авч үзье.

а. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгийн бүрэлдэхүүнд нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдлыг хамааруулсан;

б. УИХ-аас 1993 онд батлагдсан “Монгол Улсын хилийн тухай хууль”

в. УИХ-ын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох”-оор заасан;

г. Монгол Улс, ОХУ-ын хооронд 2006 онд, Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2010 онд шинээр байгуулсан хилийн дэглэмийн гэрээг УИХ-аар соёрхон баталсан;

д. Хилийн дэглэмийн болон иргэд харилцан зорчих нөхцөл, боомтын асуудлаарх Монгол Улсын олон улсын 50 гаруй гэрээ, хэлэлцээр хэрэгжиж байна;

е. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам” батлагдсан.

Цэрэг-улс төрийн нөхцөл байдал нь өөрөө байнгын өрнөлт, хөдөлгөөнд оршдог учир түүнээс улбаатай аюул, эрсдэл хэзээ, хаагуур, хэрхэн орж ирэхийг тодорхойлоход бэрхшээлтэй байж болох юм. Харин байгууллага, иргэд түүнийг үнэлж, тодорхойлох чадвартай, хариу үйлдэл үзүүлэх мэдлэг, дадлага, туршлагатай байх, түүнд шаардагдах бүх төрлийн зохион байгуулалтын арга хэмжээг төрөөс урьдчилан авах нь хамгийн энгийн бөгөөд эхний шаардлага болж байна.

Үүний тулд юуны өмнө улсын хилтэй холбоотой аливаа аюул, эрсдэлийг таньж, үнэлэх, тодорхойлох нь төрийн болон хил хамгаалалтыг зохион байгуулж

байгаа мэргэжлийн байгууллага түүний албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалттай холбоотой асуудал мөн билээ.Сүүлийн үед улс, үндэстний доторх гэмт хэрэг, хууль бус наймаа нь тухайн улсын дотоод хяналт, эдийн засгийн чадамжаас шалтгаалан даяарших хандлагатай болсон ба энэ нь цаг хугацаа, орон зайн хувьд манай улсын хилээр нэгэнт орж ирээд эхэлсэн талаар судлаачид янз бүрийн түвшинд бичиж байна. Тэгвэл бид бүс нутгийн цэрэг-улс төрийн байдлаас шалтгаалан гарч болох дараах төрлийн аюул, эрсдэл улсын хилээр нэвтэрч болзошгүй байгаад анхаарлаа хандуулах нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Гол анхаарлаа шинэ уламжлалт бус аюул заналд хандуулах.
2. Уламжлалт бус аюул заналыг ач холбогдолоор нь эрэмблэх (олон улсын терроризм, гарвал нэгтний болон шашин хоорондын мөргөлдөөн, тусгаар улс болох оролдлого, хууль бусаар засгийн эрхийг булаах санаархал, үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, зохион байгуулалттай гэмт хэрэг, улс хоорондын дайн г.м.).
3. Уламжлалт болон уламжлалт бус аюул хослон нүүрлэх.

Эдгээр аюул хил дамнасан шинжтэй байж болох тул глобал маягаар асуудлыг шийдэхээс өөр боломжгүй бөгөөд аюулыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах зэрэг асуудлууд байгаа юм.

Хэдийгээр Монгол Улс Зүүн хойд Азийн бүс нутагт бага орон боловч бусдын цэргийн шууд тусламжаас татгалзаж, тайван цагт цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, өөрийн нутаг дэвсгэр дээр гадаадын цэргийг байрлуулахгүй, дамжуулан өнгөрүүлэхгүй, цөмийн зэвсгээс ангид байна” гэдгээ тунхаглан зарласан нь тус бүс нутагт энх тайван намжмал байдал тогтоох үйл хэрэгт оруулсан хувь нэмэр юм.

Мөн Монгол Улсын Засгийн газар терроризмын эсрэг олон улсын хамтын хүчин чармайлтад өөрийн нөлөөлөл, хувь нэмрийг оруулах зорилгоор энхийг дэмжих болон олон улсын цэргийн ажиллагаанд Зэвсэгт хүчин, бусад цэргийн бүрэлдэхүүнийг оролцуулах шийдвэр гаргаж дайны дараахь гамшгийг арилгах, сэргээн босгох, энхийг дэмжих олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажиллагаанд оролцуулж эхэлсэн. Энэ нь дэлхий дахины терроризмтой тэмцэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар багагүй хүчин чармайлт гаргаж байгаа хэлбэр мөн боловч сөрөг үр дагавар авчрахыг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал, олон улсын терриризмтой хийх тэмцлийн хүрээнд АНУ-ын бодлого, үйл ажиллагааг дэмжиж идэвхтэй оролцож байгаагаас үүдэн террорист бүлэглэлүүдийн заналхийлэлд өртөх магадлал байгааг үгүйсгэж болохгүй.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого хэмээх баримт бичгийн талаарх асуудлыг сайжруулах тухай ярихын тулд түүнийг батлагдсанаас хойш буюу сүүлийн 12 жилийн хугацаанд дэлхий, бүс нутаг төдийгүй манай улсын хэмжээнд нийгэм, эдийн засаг, цэрэг-улс төрийн байдалд геостратегийн, технологийн болон соёлын шинжтэй ихээхэн хэмжээний өөрчлөлтүүд гарчээ. Үүнээс улбаатайгаар хүний сэтгэхүй, бие бялдарын хөгжил, аливаа үйл ажиллагаанд ашиглаж буй техник, технологийн чадамж улам бүр нарийн, боловсронгуй болсоор байгаа нь сайн, муу үр дагаварыг аль алинийг нь авчирч болох юм.

Түүний дотор хил хамгаалалттай холбоотойгоор дараах асуудлууд анхаарал татаж байгаагийн дотор хилийн зөрчлийн хэлбэрүүд онцгой анхаарал татаж байна. Тухайлбал, хүний наймаа, зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хар тамхи, мансууруулах

бодис хил нэвтрүүлэх зэрэг зөрчлүүд гарч сүүлийн үед зохион байгуулалттайгаар бүлэглэлийн шинж чанартайгаар гарах болсон юм. Өөроөр хэлбэл сүүлийн үед гарч буй хилийн зөрчлүүд нь илрүүлэхэд улам нарийн төвөгтэй болж, улс төр, эдийн засгийн шинж чанарыг агуулах зэргээр өөрчлөгдөх чиг хандлагатай болж байна.

Хэдийгээр төроөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хил хамгаалах албыг бие даасан, мэргэжлийн чиг хандлагатай болгон шинэчлэх зорилгоор хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байгаагийн дотор "Дархан хил хөтөлбөр", “Гэрээт хилчин төсөл” үргэлжлүүлэн хэрэгжиж байна. Харин “Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх явц эхлэл төдий байна.

Түүнчлэн хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалт дамжаанд багагүй хэмжээгээр сургаж байгаа ч энэ нь дэлхий, бүс нутагт бий болж буй өөрчлөлт түүний хурдыг гүйцэх хэмжээнд шаардлага хангахгүй байгаа юм.

Түүнчлэн бие бүрэлдэхүүний бие бялдар, гадаад хэл, компьютер, албаны мэдлэгийн түвшин, техникийн чанар, илрүүлэлтийн хэрэгслүүдийн боломжийг улам илүүтэйгээр нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Үүний тулд “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д чанарын дорвитой өөрчлөлт хийж, үүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагууд нягт харилцан уялдаатайгаар дэс дараатайгаар хэрэгжүүлэх, чиглэл тус бүрээр үндсэн болон дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй асуудал мэт санагдана.

## Дүгнэлт

Энэхүү илтгэл, судалгааны ажил нь үндсэндээ 2000-аад оноос хойш өрнөж байгаа асуудлууд учир явцуу хүрээнд хийгдсэн байж болох талтай ч асар их хэмжээний өөрчлөлт, өрнөлтийг дэлхийд болон Монгол Улсын хэмжээнд бий болгосноор түүний үр нөлөө нь өдгөө үргэлжлэл хэлбэрээр үр дүнгээ эерэг, сөрөг байдлаар өгсөөр байгаа “цэрэг-улс төрийн байдал” нь эрдэмтэд, судлаачдын хувьд орчин үеийн томоохон судалгааны обьект болсоор байгаа билээ.

Дэлхий дахинд болон улс орны нийгэм, эдийн засаг, цэрэг-улс төрийн салбарт бодитойгоор өрнөж, өөрчлөгдөж буй дээрх нөхцөл байдлыг бид болох ёстой зүйл мэтээр хүлээн авах нь улс, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд үл нийцэх бөгөөд үүсч буй нөхцөл байдалтай уялдуулан өөрийн үйл ажиллагаандаа бодлогын шинж чанартай өөрчлөлт, шинэчлэлт хийж, албаны арга, ажиллагаагаа боловсронгуй болгох нь өнөөгийн тулгамдаж буй асуудал мэт санагдана.

Үүнтэй холбоотойгоор хил хамгаалалтын арга тактик, үйл ажиллагааныхаа цар хүрээ, бие бүрэлдэхүүний албаны бэлтгэлжилт, ур чадвар зэрэг асуудалд дорвитой өөрчлөлт оруулах, энэ асуудлыг төрөөс бодлогоор дэмжих буюу "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д нэн даруй тодотгол хийх, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах шаардлага гарч байгаа билээ.

“Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” хэмээх баримт бичгийг баталж, хэрэгжүүлэх үйл явц эхэлсэн. Түүнээс хойш өдгөө 12 жил өнгөрсөн хэдий ч түүний биелэлтийг гарган үр дүнг тооцож үзээгүй гэж болно. Түүнээс гадна уг баримт бичгийн 3.4-д “Хилийн талаар баримтлах бодлогод олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутаг, хил залгаа улс дахь цэрэг-улс

төрийн байдал, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх" гэсэн заалт байдаг. Энэ заалт ч мөн адил үндсэндээ хэрэгжээгүй бөгөөд ямар нэгэн тодотгол огт хийгдээгүй. Түүнээс гадна төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа аль ч талдаа зөвхөн хил хамгаалах байгууллагын үүрэг мэт ойлгох нь угаас өрөөсгөл бөгөөд үүнд хамгийн идэвхитэй үүрэг хүлээх субьект буюу “Төр” өөрөө хайнга хандсаар ирсэн ба уг бодлогыг “лоозон” мэт ойлгож хэрэгжүүлэлт удааширч түүнийг сайжруулах, тодотгох асуудал огт хөндөгдөөгүй юм.

Үүнтэй холбоотойгоор хил хамгаалалтын арга тактик, үйл ажиллагааныхаа цар хүрээ, бие бүрэлдэхүүний албаны бэлтгэлжилт, ур чадвар зэрэг асуудалд дорвитой өөрчлөлт оруулах, энэ асуудлыг төрөөс бодлогоор дэмжих буюу “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д нэн даруй тодотгол хийх, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах шаардлага гарч байгаа билээ.

Иймд дэлхийд болон манай улсад гарч буй өөрчлөлт, түүний эрчимтэй өрнөлтүүдийг харгалзан үзэж төрөөс хилийн талаар баримтлах бодлогодоо шинжлэх ухаанд суурилсан бодлогын чанартай дорвитой өөрчлөлт хийх асуудлыг шуурхайлах цаг нэгэнт болжээ.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа О.Азхүү*

## УЛСЫН ХИЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН АРГААР ХАМГААЛАХ АСУУДАЛД

Улсын хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь улсын хилийг газар, усан дээр манаж хамгаалах, хүн, ачаа тээш, тээврийн хэрэгслийг улсын хилээр шалгаж нэвтрүүлэх, хил зөрчигчид, хорлон сүйтгэгчид, алан хядагчтай тэмцэх, хүчний болон хил хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус хил дамнасан наймаа(контрбанд)-тай тэмцэх, хүн, тээврийн хэрэгсэл улсын хилийг хууль бусаар нэвтрэх явдлыг таслан зогсоох зэрэг үйл ажиллагаагаараа бусад хүчний байгууллагуудын үйл ажиллагаанаас ялгардаг.

Улсын хил хамгаалалт нь улсын аюулгүй байдлыг хангах бүтцийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төрийн хилийн бодлогоор түүнийг хэрэгжүүлдэг. Улсын төр, захиргаа, орон нутгийн байгууллагууд өөрсдийн эрх мэдлийнхээ хүрээнд улс төр, эрх зүй, зохион байгуулалт, дипломат харилцаа, эдийн засаг, батлан хамгаалалт, хил, тагнуул, сөрөг тагнуул, эрэл хайгуул, гааль, ургамал хорио цээр, байгаль хамгаалал, экологийн асуудлаар холбогдох арга хэмжээнүүдийг авдаг.

Улсын хил хамгаалах арга хэмжээнүүдийг авахдаа олон улсын гэрээ, өөрийн улсын хууль тогтоомжоор баталсан улсын хилийн статусыг харгалздаг.

Өнөөдөр улсын хилийг Монгол Улсын Хилийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д “Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн.Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ,